

БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТЫН ЯАМ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ, БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА” ХХК-НИЙ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.БАТТУУЛ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН
НУТАГТ ОРШИХ ХОТГОРЫН ЧУЛУУН НҮҮРСНИЙ
ОРДЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV 017062, MV-021487, MV-021488/
/РЕГЕСТРИЙН ДУГААР : 2862468/

Хянасан:

БОУАӨЯ-БОУАХэлтэсийн
Байгаль орчны стратегийн үнэлгээ хариуцсан
Ахлах мэргэжилтэн

Б.Солонго

Боловсруулсан:

“Сэкер ресорсус монголиа” ХХК-ний
Байгаль орчны мэргэжилтэн

Ч.Төрбат

АГУУЛГА


1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн товч мэдээлэл.....	3
1.2 Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал	4
2 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
2.1 Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	9
2.1.1 Хөрс	9
2.1.2 Ус	10
2.1.3 Биологийн олон янз байдал, ургамал, амьтан бусад	10
3 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	12
5. ЗАРДЛЫН ХУРААНГУЙ.....	12
6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВӨГӨӨ	13
6.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13
6.2 Ногоон байгууламжийн төлөвлөгөө	27
6.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	27
6.4 Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	29
6.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	29
6.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	29
6.7 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	35
6.8 Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө	44
6.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	44
6.10 Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	60
Хүснэгт № 1 Зардлын хураангуй	13
Хүснэгт № 2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
Хүснэгт № 3 Ногоон байгууламжийн төлөвлөгөө	27
Хүснэгт № 4 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	28
Хүснэгт № 5 Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	29
Хүснэгт № 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	31
Хүснэгт № 7 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	35
Хүснэгт № 8 Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	44
Хүснэгт № 9 Дуу чимээний хэмжилтийн үр дүнгийн харьцуулалт (MNS4585:2025)	45
Хүснэгт № 10 Төслийн дуу чимээний хяналт мониторингийн цэгүүд	45
Хүснэгт № 11 Төслийн агаарын чанарын хяналт мониторингийн цэгүүд	46
Хүснэгт № 12 Төслийн усны хяналт мониторингийн цэгүүд	50

Хүснэгт № 13 Төслийн ургамлан нөмрөгийн хяналт мониторингийн цэгүүд	52
Хүснэгт № 14 Төслийн амьтны аймгийн хяналт мониторингийн төлөвлөгөө	53
Хүснэгт № 15 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	55
Хүснэгт № 16 БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	А
Зураг 1 Талбайн байршил	3
Зураг 2 Ашиглалтын талбайн агаар сансрын зураг	5
Зураг 3 Дуу чимээний хяналт мониторингийн цэгүүд	46
Зураг 4 Агаарын чанарын хяналт мониторингийн цэгүүд	48
Зураг 5 Хөрсний хяналт мониторингийн цэгүүд	50
Зураг 6 Усны хяналт мониторингийн цэгүүд	51
Зураг 7 Ургамлын хяналт мониторингийн цэгүүд	53
Зураг 8. Орчны хяналт мониторингийн цэгүүд	59

1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч мэдээлэл

Сэкер Ресорсус Монголиа ХХК нь анх 2006 онд ГобиКоул Энд Энержи нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 2022 онд нэрээ өөрчлөн, Сингапур улсын хөрөнгө оруулалттайгаар Сэкер Ресорсус Монголиа ХХК болсон. Хотгорын нүүрсний орд нь зэргэлдээ болон үргэлжилсэн 7 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг (MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV 017062, MV-021487, MV-021488) хамран байрладаг. Анх 11340Х хайгуулын тусгай зөвшөөрлийг ГУУКА-ны даргын 897 тоот шийдвэрээр 2006 оны 02 сарын 13 өдөр Гоби Коул энд Энержи ХХК-д олгосон байдаг ба үүний дараа 7459Х, 7458Х, 12728А, 13782Х тусгай зөвшөөрлийн талбайнуудыг авч өөрийн хөрөнгөөр геологи хайгуулын ажлыг хийж гүйцэтгэж, улмаар ашиглалтын тусгай зөвшөөрөл болгосон байна. Засаг захиргааны хувьд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун урагш ойролцоогоор 900 км, Баянхонгор аймгаас урагш 265 км, Шинэжинст сумын төвөөс баруун хойш 7 км-ийн зайд оршино. Физик газарзүйн мужлалаар говийн их мужийн баруун мужид, Алтайн нурууны зүүн өмнөд талын салбар Гичгэний нурууны зүүн урд үзүүрийн Саманд уулын хойд бэлд далайн түвшинээс дээш 2150 гаруй метрийн өндөрт байрлана.



Зураг 1 Талбайн байршил

1977-1978 онд Н.Авид Хотгорын чулуун нүүрсний ордыг шинээр илрүүлж 4 канав, 24 цооног буюу 1957т.м өрөмдлөгийн ажил гүйцэтгэж нүүрсний нөөцийг 4.09 сая.тн-оор тооцсон байдаг.

Хотгорын чулуун нүүрсний ордод 2007-2010 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2011 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны ХХ-17-01

тоот дүгнэлтийг үндэслэн АМГ-ын даргын 2012 оны 02 сарын 16-ны өдрийн 94 тоот тушаалаар нийт боломжтой болон бодитой (В+С) зэрэглэлээр 160.1 сая.тн, үүнээс бодитой (В) зэрэглэлээр 118.3 сая.тн, боломжтой (С) зэрэглэлээр 41.8 сая.тн чулуун нүүрсний нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд хүлээн авсан байна. Мөн Хотгор чулуун нүүрсний ордын зүүн хэсэгт 2006-2017 онуудад гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны ХХ-13-07 тоот дүгнэлтийг үндэслэн АМГТГ-ын даргын 2019 оны 09 сарын 16-ны өдрийн н/112 тоот тушаалаар нийт боломжтой болон бодитой (В+С) зэрэглэлээр 171.04 сая.тн, үүнээс бодитой (В) зэрэглэлээр 124.58 сая.тн, боломжтой (С) зэрэглэлээр 46.46 сая.тн чулуун нүүрсний нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэжээ. Оновчлолоор тогтоосны дагуу ил уурхайн хүрээнд 108.1 сая тонн геологийн нөөц хамрагдаж байгаа бөгөөд хаягдал, бохирдлын тооцоог тусгаснаар үйлдвэрлэлийн нөөц 109.6 сая тонн байна. Уурхайгаас 2024 оны 01 сарын 01-ний өдрийн байдлаар нийт 32.5 мян.тн нүүрсийг орон нутгийн хэрэгцээнд олборлоод байна.

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК нь 2025 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тодотгол тайлан, ашиглалтын талбайнуудад эрх бүхий мэргэжлийн байгууллагаар шинэчлэн боловсруулуулж, холбогдох байгууллагаар 2025 оны 8-р сарын 27-ны өдөр батлуулсан. Мөн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу 2011 оноос эхлэн археологийн авран хамгаалах хайгуул судалгаа, малтлага судалгааны ажлуудыг жил бүр шат дараатайгаар хэрэгжүүлж байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон биелэлтийг БОАЖЯ-аар жил бүр батлуулж, мөрдлөг болгон ажиллаж байна.

1.2 Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал

Баянхонгор аймаг нь Монгол улсын нутаг дэвсгэрийн баруун төв хэсэгт байрлаж Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Завхан, Архангай аймгуудтай хил залгадаг ба нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 116 мянган ам километр болно. Нутгийн хойд хэсэгт Хангайн нурууны өмнө талын тэгш өндөрлөг, дунд хэсгээрээ Их нуруудын хотгорын төгсгөл тал хээр, өмнөд хэсгээрээ Алтайн цаад говийн цөлөрхөг хээрийн бүсийн хэсэгт хамаардаг.


Баянхонгор аймаг нь хөрс, цаг уурын олон бичил мужид хуваагддаг. Нар салхины эрчим хүчний нөөц сайтай ба Умардын хүйтэн чийглэг уур амьсгалаас өмнөдийн хэт хуурайд шилжих явцад үүссэн эрс тэс уур амьсгалтай.

Физик газар зүй

Хотгорын чулуун нүүрсний орд засаг захиргааны хувьд Монгол улсын баруун өмнөд хэсэг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун урагш ойролцоогоор 900 км, Баянхонгор аймгаас урагш 265 км, Шинэжинст сумын төвөөс баруун хойш 7 км-ийн зайд оршино. Физик газарзүйн мужлалаар говийн их мужийн баруун мужид, Алтайн нурууны зүүн өмнөд талын салбар Гичгэний нурууны зүүн урд үзүүрийн Саманд уулын хойд бэлд оршино. Орд нь Говь-Алтайн нурууны дунд хэсэг (Баянцагааны нуруу, Шинэжинст уулын хооронд) оршдог тул ордын үндсэн хэсэг нь уул,

толгодорхог, гадаргуутай районд багтах бөгөөд далайн түвшнээс дээш 2150 гаруй метрийн өндөрт байрлана. Тус уурхайн талбайн хамгийн өндөр цэг нь Саманд уул ба түүний үнэмлэхүй өндөр нь далайн түвшнээс дээш 2347 метр юм. Талбайн гадаргуу нь гуу, жалгаар нэлээд хэрчигдэлтэй, тэдгээрийн адгуудад хошуурсан туугдсууд үүсч, өөрийн гэсэн онцлогтой чулуурхаг товгорхог гадаргууг үүсгэсэн байдаг. Орд газар нь Төв азийн гадагшаа урсгалгүй ай савын бүсэд багтдаг.

Баянхонгор аймаг нь Монголын баруун өмнөд хэсэгт Хангайн нурууны өмнөх өндөрлөг, Говь-Алтайн нурууны уулс, Алтайн өврийн говийн хамран говь хангайн бүсийг дамнан оршдог аймаг юм. Иймд нутаг нь уул тал хөндий хосолсон хэлбэр бүхий гадаргатай. дунд хэсэг Шинэжинст сум нь өргөргийн $44^{\circ}44'10''$, уртрагийн $100^{\circ}23'40''$ солбицолд орших бөгөөд далайн түвшнээс дээш 1630 метр өндөрт байрладаг бөгөөд зүүн хойд талаараа Алтайн нурууны уулс, төв хэсгээр Улаанхан, Хартолгой, Хөндлөн зэрэг уулс, Өргөөтийн талууд оршино. Тус сумын хамгийн өндөр цэг Их Богд Уул 3957 метр, хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 1200 метр өндөр нутгийн захад оршино.



Зураг 2 Ашиглалтын талбайн агаар сансрын зураг

Уур амьсгал

Шинэжинст сум нь нутаг дэвсгэрийн мужлалаар говийн бүс, мелиорацийн мужлалаар умард говийн бүсэд, цаг уурын мужлалаар нэн хуурай дулаавтар мужид багтаж байна. Ордынрайон нь эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд багтана. Уур амьсгалын тодорхойлолтыг Шинэжинст цаг уурын өртөөний олон жилийн ажиглалтын мэдээг үндэслэн бичив. Цаг уурын шинэжинст өртөө нь 1972 оны сүүлчээр байгуулагдсан манай улсын цаг уурын сүлжээний нэг тулгуур цэг бөгөөд хойд өргөргийн $44^{\circ}03'$, зүүн уртрагийн $99^{\circ}16'$, далайн түвшнээс 2219,2 метр өндөрт оршино. Энэ бүс нутаг жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа урт, агаарын температурын жилийн болон хоногийн хэлбэлзэл ихтэй, хур тунадас

ховор хэт хуурай. Жилдээ 120-180мм хур тунадас ордог бөгөөд хамгийн хүйтэн нь 1-р сард $-30-35^{\circ}\text{C}$, харин зундаа 7-8-р сард хамгийн $+25+30^{\circ}\text{C}$ байдаг. Жилийн дундаж температур $0-(+1)^{\circ}\text{C}$ - т хэлбэлзэх ба салхины чиглэл баруун, баруун урдаас зүүн, зүүн хойшоо байдаг, дундаж хурд нь 2.8-7.3 м/сек-ийн хооронд байна.

Өвөл: Эхний цас оролт 10-р сарын эхэнд орох ба хожуу цас оролт 10-р сарын 28-нд ордог. Эцсийн цас оролт 2-р дүгээр сарын 11-нд орох ба хожуу цас оролт 5-р сарын 15-нд ордог. Цасан бүрхүүлтэй өдрийн тоо 49 өдөр, цасан бүрхүүлийн нягт нь $0,6 \text{ г/см}^3$ байдаг. Эцсийн хүйтрэл 5-р сарын 17-ны үеэр тохиолдох бөгөөд хүйтрэлгүй хугацааны дундаж үргэлжлэл нь 147 хоног байна.

Хавар: Тус сумын нутаг 4-р сарын 15-ний үеэр хавар эхэлж, 5-р сарын 3-ны үеэр шувтрах бөгөөд нийтдээ 18 хоног үргэлжилнэ.

Зун Харин зуны улирал 5-р сарын 3-ны үеэс хоногийн дундаж агаарын температур харин зундаа 7-8-р сард хамгийн халуун $+10^{\circ}\text{C}$ давж дулаарахаас эхлэн 10-р сарын 2 буюу $+10^{\circ}\text{C}$ -ийг давж сэрүүсэх хүртэл 152 хоног үргэлжилнэ.

Намар: Хоногийн дундаж агаарын температур $+10^{\circ}\text{C}$ -аас доошлох буюу -5°C болж сэрүүсэх хүртэлх хугацааг намрын улирал гэж монгол орны уур амьсгалын мужлалаар тогтоожээ. Тус сумын нутаг намар 10-р сарын 2-ний үеэр эхэлж, 11-р сарын 13-ний үеэр дуусах дунджаар 41 хоног үргэлжилнэ.

Хөрс

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийн хөрсний төрөл, тархац үржил шим тариалангийн бүс, дэд бүс бүрд харилцан адилгүй байдлаар тархсан байдаг. Талбайн баруун талаар ухаа гүвээ толгодын маш нимгэн ялзмагт үеийн давхаргатай, карбонатлаг, цөлөрхөг хээрийн бор хөрс, дунд хэсгээрээ тал газрын ба уулсын хоорондох маш нимгэн ялзмагт үе давхаргатай, зузаан шороон үетэй. Талбайн баруун урд талдаа намхан уул, толгодтой бусад хэсэгтэй гүвээлэг болон тэгш, гадаргадаа жижиг үйрмэг чулуутай (10-15%). Өнгөн хөрс нь салхины элэгдэлд бага зэрэг орсон. Хөрсний ялзмагт үеийн зузаан 12 см, шороон үеийн зузаан нь 1.0-1.7 байна. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүн нийт талбайд элс, элсэнцэр, хөнгөн шавранцар байна. Уур амьсгалын нөлөөгөөр говийн хөрсний ургамалт үе нь нимгэн байдгаас гадна хуурай, элсэрхэг байх ба шим тэжээл маш нимгэн байдаг.

Ургамал

Уурхайн талбайд ургамлын нөмрөгийн хувьд уулыг хээрийн Таана-заримдаг сөөгөнцөр-өдлөг хялганат, таана-үстэн-заримдаг сөөгөнцөрт гэсэн 2 төрлийн хэв шинжүүд бүлгэмдлүүд 15-25% бүрхэц үүсгэн 0.85-1.06ц/га ургацтай ургаж байна. Тухайн нутгийн цаг уур, хөрсний онцлогоос хамаараад ургамлын нягтрал багатай, их сийрэг тачир. Ургамалшилт нь хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь, таана, мангир, хөмүүл, хазаар, баглуур зэрэг олон наст ургамал, бударгана, харгана гэх мэтийн модлог, бутлаг говийн ургамал ургадаг. Хавар 4-р сараас ургамал ургаж цэцэг, навчаа дэлгэж эхлэх ба намар 9-р сараас гандах байдалтай болж ирнэ. Голлон таана баглуур ургах ба хялгана, агь, тэсэг сийрэг бөгөөд тачир тархалттай байна.

Амьтны аймаг

Шинэжинст сумын нутагт байрлах талбайн байгалийн хэв шинж нь мөлхөгч амьтны олон зүйл байрших тохиромжит нутаг юм. Тус талбайд сээртэн амьтаас загас, хоёр нутагтны ангийн төлөөлөгч тархцын хүрээнд тэмдэглэгдээгүй болно. Ашиглалтын талбай түүний орчим нутгийн шувуудын зүйлийн бүрдэл нь амьдрах орчны хэв шинж, улирлын ялгаатай байдал зэрэг биологийн хүчин зүйлээс хамаарч суурин үүрлэж, өндөглөдөг, мөн зөвхөн нүүдлийн үед дамжин өнгөрөх тул тоо толгой зүйлийн баялаг харилцан адилгүй. Тухайн район нь ан амьтадаар нэлээд баялаг, уул, асга, хадандаа аргаль угалз, янгир, ирвэс байдаг. Араатан амьтдаас үнэг, хярс, мануул, цөөн тооны чоно, мэрэгчдээс үлийн цагаан оготно, олби, орог саарал, шар сүүлт, алаг даага, туулай зэргийг нэрлэж болно. Жигүүртэн амьтдаас бүргэд, тас, элээ, хэрээ, харцага, идлэг шонхор, шар шувуу, сар, болжмор, ногтруу, ууль, тагтаа, чогчиг, хуланжороо зэргийг нэрлэж болно. Хэвлээр явагчдаас могой, замба, хонин ба могой гүрвэлүүд, шавж болон жижиг далавчтанаас арваалж, аалз, голио, царцаа зэргийг нэрлэж болно.

1.2.1 Төсөл хэрэгжүүлж буй нутгийн байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Баянхонгор аймаг нь урд талаараа БНХАУ-тай, баруун талаараа Говь- Алтай, баруун хойд хэсгээр Завхан, хойд талаараа Архангай, зүүн, зүүн хойд талаараа Өвөрхангай, зүүн урд хэсгээрээ Өмнөговь аймгуудтай тус тус хиллэн оршино. Аймгийн төв Баянхонгор хот нь Улаанбаатар хотоос 630 км зайтай.

Хүн ам: Аймгийн суурин хүн амын тоо 2022 оны жилийн эцсийн байдлаар 89643 үүнээс 45453 /50,7%/ эмэгтэй, 44190 /49,3%/ эрэгтэй Баянхонгор аймагт амьдарч байна. Нийт хүн амын 32665 нь аймгийн төвд, 10017 нь сумын төвд, 46961 хүн нь хөдөө амьдарч байна.

Өрхийн тоо 26737 болж эрэгтэй өрхийн тэргүүлэгчтэй өрх нь 19432 / 72,7%/, эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй 7305 / 27,3%/, өрх байна. Нийт өрхийн 9746 нь аймгийн төвд, 3057 нь сумын төвд, 13934 өрх нь хөдөө амьдарч байна.

Баянхонгор аймгийн дундаж наслалт 2020 онд 70.9 байсан бол 2022 онд 71.7 болж 0.8 жилээр нэмэгдсэн байна. Эрэгтэй дундаж наслалт 2022 онд 68.4, эмэгтэй дундаж наслалт 73.7 байгаа нь эмэгтэйчүүд 5.3 жилээр илүү урт насалж байгааг харуулж байна.

Боловсрол: Баянхонгор аймгийн боловсрол, шинжлэх ухааны газрын мэдээгээр 2022 2023 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын 32 сургуульд 19410 суралцагч, сургуулийн өмнөх боловсролын 43 байгууллагад 6824 хүүхэд сурч хүмүүжнэ.

Сургуулийн бүлэг дүүргэлт 28, цэцэрлэгийн бүлэг дүүргэлт 32 байгаа бол цэцэрлэгийн хамран сургалт 87, сургуулийн хамран сургалт 98 хувьд хүрчээ. ЕБС-д 973 багш ажиллаж байгаа нь багшийн хангалт 99 хувь, СӨБС 210 багштай үйл ажиллагаа явуулж байгаа нь багшийн хангалт 98 хувьтай байна.

Эрүүл мэнд: 2022 оны байдлаар аймгийн хэмжээнд 1503 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 214 төрөлтөөр буурсан байна. Нийт төрсөн эхийн 94.9 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, сум дундын, сумын эмнэлэгт 5.1 хувь нь төржээ. Нялхсын эндэгдэл 2022 оны байдлаар 16 гарчээ. Аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар нийт 8128 халдварт өвчин бүртгэгдэж 10,000 хүн амд 913.3 байгааг өнгөрсөн оны мөн үетэй (2043.6) харьцуулахад 2.6 дахин буурч, коронавирусийн халдварын шалтгаант 2 нас баралт бүртгэгдсэн байна. Нийт 14182 түргэн тусламжийн дуудлага бүртгэгдсэний 22.6 хувийг алсын, 7.4 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн нийт дуудлагын тоо өсөж, нийт дуудлагад эзлэх осол гэмтлийн дуудлага буурсан байна.

Идэвхтэй ажил хайгч иргэд: 2022 оны байдлаар аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэд 1027 болж өмнөх сараас 56 хүнээр буюу 5.4 хувиар буурчээ. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн 564 буюу 54.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-44 насныхан 74.9 хувь буюу 770 иргэн, 45 дээш насныхан 257 иргэн 25.1 хувийг эзэлж байна. Шинэ ажлын байранд нийт 301 иргэн ажилд орсон бөгөөд үүний 50.8 хувь буюу 153 нь эмэгтэйчүүд байна.

Мал аж ахуй: Мал тооллогын дүнгээр 2022 оны жилийн эцэст манай аймгийн мал сүргийн нийт дүн 3719,6 мянга болж, 2021 оны нийт дүнгээс 17.6 хувь буюу 691.5 мянган толгойгоор өслөө. Тооллогын дүнгээр адуун сүргийн тоо 160.4 мянга, үхэр 223 мянга, тэмээ 45.5 мянга, хонь 1108 мянга, ямаа 2182,7 мянган толгой болж өссөн.

2022 оны тооллогын дүнгээр 15.3 мянган малтай өрх тоологдож, өмнөх оныхоос 154 өрх буюу 0.9 хувиар буурсан байна. Нийт малтай өрхийн 85.0 хувь буюу 13.1 мянган өрх нь жилийн дөрвөн улирлын туршид малаа маллаж, амьжиргааны эх үүсвэрээ болгож байгаа малчин өрх байна. Малчин өрхийн тоо өмнөх оноос 211 өрх буюу 7.5 хувиар өслөө. 2022 оны тооллогын дүнгээр 22.6 мянган малчин тоологдлоо. Нийт малчдын 12.6 мянга буюу 55.3 хувь нь эрэгтэй, 9923 мянга буюу 44.7 хувь нь эмэгтэй малчид байна.

2022 оны том малын зүй бус хорогдлын мэдээгээр нийт 3737 толгой мал хорогдсон нь оны эхний малын 0.1 хувийг эзэлж байна. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл тэмээ 11, адуу 226, үхэр 515, хонь 1188, ямаа 1797 толгой тус тус хорогджээ

Газар тариалан: Ургац хураалтын явцын мэдээгээр аймгийн хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын 31- ний байдлаар 1692.6 тонн төмс, 814.1 тонн хүнсний ногоо хураасан нь өмнөх оны мөн үеэс төмс 0.07 тонн (0.04 %)-оор, хүнсний ногоо 204.1 тонн (20.1 %)-оор тус тус буурсан байна.

Аж үйлдвэр: Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт 2022 оны 11 дүгээр сард өссөн дүнгээр 72 тэрбум 40 сая төгрөгт хүрчээ. өмнөх оны мөн үеэс 20 тэрбум 488 сая төгрөг буюу 28.4 хувиар өссөн байна. Нийт үйлдвэрлэлтийг салбараар авч үзвэл: Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 21 тэр бум төгрөг буюу 33.8 хувиар өссөн, боловсруулах аж үйлдвэрийн борлуулалт -417,4 сая төгрөг буюу 22,6 хувиар буурсан, цахилгаан, хий, уур, агааржуулалтын борлуулалт -719,6 сая төгрөг буюу 15,4 хувиар буурсан, ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны борлуулалт 428,2 сая төгрөг буюу 18.5 хувиар өссөн байна. Үйлдвэрийн газрууд 6720,7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 6720,7 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өнгөрсөн он мөн үеэс 24,6 сая буюу 0,37 хувиар нэмэгдсэн байна. Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 537 болж 6 хүнээр буурсан үзүүлэлтэй байна.

2 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хотгорын ордоос нүүрс олборлох, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2025 онд шинэчлэн боловсруулсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг.

Хотгорын ордоос нүүрс олборлох, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон.

2.1 Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

“Сэкер Ресурсус Монголиа” ХХК-ийн Хотгорын нүүрсний й ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг ЗГ-ын 2023 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалын дагуу байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзлээ. Агаар

Цаг агаарын хуурай хуурайшилттай болон шуургатай өдрүүдэд уурхайд тэсэлгээ хийх, нүүрс олборлох болон тээвэрлэх үед тоос, хорт хий, уулын машин механизм, тоног төхөөрөмжийн дуу чимээгээр агаарын физик бохирдолт явагдаж болзошгүй, мөн тэсэлгээний үед болон шатах тослох материалын машин механизмын яндангаар хаягдах хорт хий хаягдах, химийн бодисын болон хатуу хог хаягдал зэргийн болзошгүй нөлөөгөөр агаар химийн нөлөөлөлд орох зэргээр давхардмал нөлөөлөлд орох магадлалтай. Уурхайн хаягдлын овоолго, нүүрсний овоолгын хэсгүүдээс салхиар дамжин агаарт тоосжилт үүсэх, автомашины хөдөлгүүрээс гарах утаа агаарын чанарын нөлөөлөл үүсгэж болзошгүй.

Агаар орчны бохирдолт:

- Хөрс хуулалт
- Нүүрс олборлолт
- Овоолго

Нөлөөлөлд өртөх объект

- Уурхайн түр кемп орчим
- Шинэжинст сум, багийн оршин суугчид
- Амьтан
- Ургамал

2.1.1 Хөрс

Хөрс, газрын гадарга нь уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас талхлагдах, элэгдэх эвдэрхийн зэрэгцээ тоос, хатуу шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож болзошгүй. Мөн хөрс хуулалт болон төслийн үйл ажиллагааны явцад хөрс эвдрэлд орохын зэрэгцээ үржил шимээ алдах сөрөг нөлөөлөл байна. Шатахуун түгээх станц, авто засварын төв зэрэг нь хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй тул талбайг цементлэх шаардлагатай.

Хөрс бохирдолт

- Ашиглалтын явцад хөрсний физик-механикийн болон химийн макро ба микро элементүүдэд өөрчлөлт орсон

- Хөрсний элэгдэл болон эвдрэл үүссэн
- Уурхайн малталт болон гадаад овоолгын суурийн талбайд шимт хөрс өртсөн
- Хүнд даацын машин, механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээсэн

- Хатуу болон шингэн хог хаягдлын улмаас хөрсөнд бохирдол үүссэн

Нөлөөлөлд өртөх объект

- Шимт хөрс бүхий газар
- Малын бэлчээр
- Амьтан ургамал

2.1.2 Ус

Газрын гадаргын болон газрын доорх усан орчин бохирдсон нөхцөлд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлж болзошгүй. Газрын доорх усны ашиглалтаас усны нөөц багасах, усны түвшин буурах зэрэг нөлөөлөл үүсэж болзошгүй.

Гадаргын ба гүний ус

- Бохир усны цэвэршүүлэлт стандарт шаардлагад нийцээгүй байгаль хаясан тохиолдолд усан орчин бохирдох

Бохир усны цэвэршүүлэлт стандарт шаардлагад нийцээгүй байгаль хаясан тохиолдолд усан орчин бохирдох Нөлөөлөлд өртөх объект

- Хүн ба Мал
- Амьтан ургамал

2.1.3 Биологийн олон янз байдал, ургамал, амьтан бусад

Амьтны болон ургамлын аймагт үзүүлж болзошгүй нөлөөлөл

Ургамлан нөмрөг

- Төсөл хэрэгжих хугацаанд уурхайн олборлолт, барилга байгууламж, хөрсний овоолгууд зэргээс нийт 1,626.7 га талбай эвдрэлд өртөж, шимт хөрсийг хуулснаар ургамлан нөмрөг устах, нөлөөлөлд өртөх

- Төслийн үйл ажиллагааны үед үүсэх тоосжилтын нөлөөгөөр тухайн хэсгийн ургамлуудын физиологийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж доройтох.

- Ашиглах химийн бодисуудын ачиж, тээвэрлэх явцад сав баглаа боодол гэмтэх, хадгалалт, ашиглалтын стандарт, хэвийн үйл ажиллагаа алдагдсанаар үүсэх асгаралтын улмаас ургамлан нөмрөг нөлөөлөлд өртөх

. • Машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдан шатах тослох материал асгарсны улмаас ургамлан бүрхэвч бохирдож болзошгүй.

Амьтны аймаг

• Уурхайлалд өртөх талбайн хэмжээгээр биологийн олон янз байдлын амьдрах орчин доройтох, амьдрах орчноосоо дайжих

• Машин техник, үйлдвэр, станц, тэсэлгээ болон бусад дуу чимээ ихээр үүсгэх үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ, техникийн хөдөлгөөнөөс зэрлэг амьтдад дайжих, үргэх

• Цахилгаан станц болон ЦДАШ зэргээс шувууд хавар, намрын нүүдлийн үедээ утас мөргөх, цахилгаанд цохиулж эндэх

Болзошгүй нөлөөллийн эх үүсвэр

- Уулын бэлтгэл ажлууд
- Уурхайн хөрс хуулалт ба карьер
- Өрөмдлөг, тэсэлгээ
- Олборлолт / нүүрс ачих тээвэрлэх /
- Хаягдал аж ахуйн /нүүрсний хаягдал, хаягдлын гадаад, дотоод овоолго /
- Талбайн гадаргын ус зайлуулах систем
- Шатах тослох материалын агуулах, шатахуун түгээх станц
- Зам, тээвэр
- Бохир ус цэвэрлэх байгууламж
- Хүн, машин механизм хөдөлгөөн

Нөлөөлөлд өртөх объект

1. Уурхай орчмын ургамал амьтан

3 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар Монгол улсын хууль тогтоомж, стандартуудыг даган мөрдөж, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний тодотголийн тайланд тусгагдсан зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэн төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилготойгоор ажиллаж байна.

Мөн Монгол Улсын хууль тогтоомж, стандартад нийцүүлэн байгальд ээлтэй орчин үеийн технологи нэвтрүүлэх, байнгын хяналт, мониторинг хийх, олборлолтын бүхий л үе шатанд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны стандартуудыг хэрэгжүүлэх замаар байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хангасан байгаль орчны зохистой бодлого барин ажиллаж байна.

Тус төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээ зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгасан.

Энэхүү төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа Хотгорын чулуун нүүрсний орд ашиглах төслийн БОМТ-г байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9-р зүйл, Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам, БОАЖС-ын 2019 оны А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу БОНХСайдын 2014 оны 117 тоот “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ийн 4-р хэсэг Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг баримтлан боловсруулав.

5. ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

Энэхүү төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгааны үр дүнг үндэслэн боловсруулсан ба төслөөс байгаль орчин, нийгэмд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг тусгав. Арга хэмжээний төлөвлөгөөг дараах агуулгын хүрээнд боловсруулав. Үүнд:

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
- Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэрийн төслийн БОННУ тодотгол 2025 оны 8-р сарын 27-ны өдөр батлагдсан бөгөөд тус тайланд

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд нийт 5 жилийн хугацаанд 1,120,135,000 төгрөг, эхний жилийн зардал 195.4 сая төгрөг зарцуулахаар тусгасан байна.

Хотгорын чулуун нүүрсний уурхайн 2025 оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу бүтэн жилийн хугацаанд буюу 347 хоногт ажилласан бол 10,001,60 тн нүүрс олборлолт хийж, 54,312,000м³ хөрс хуулалт хийгдэх байсан боловч багийн иргэдийн нийтийн хурал хүлээгдсэн шалтгааны улмаас уурхайн БОННУ-ний тодотголын тайлан 2025 оны 8-р сарын 27-ны өдөр батлагдсан тул энэхүү БОМТ батлагдсаны дараа буюу 2025 оны 10-р сараас уурхайн үйл ажиллагаагаа явуулж эхлэнэ гэж тооцож үлдсэн 2 сарын хугацаанд 12,765,200м³ хөрс хуулалт хийж 2,224,200тн нүүрс олборлох төлөвлөгөөтэй болсон.

Хүснэгт № 1 Зардлын хураангуй

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		Зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах	68,500,000
3	Ногоон байгууламжийн төлөвлөгөө	ҮАЗ
4	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	15,000,000
5	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
		36,480,000
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	24,500,000
7	Удирдлага зохион байгуулалт	ҮАЗ
	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	50,945,000
Нийт зардал		195,425,000

6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВӨГӨӨ

6.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн хүрээнд гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр буюу агаарын чанар, газрын гадарга, хөрсөн бүрхэвч, усан орчинд, биологийн олон янз байдалд тодорхойлж, сөрөг нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

Хүснэгт № 2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.₮	Нийт зардал, сая.₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	8	9	10
Агаарын чанар									
1	Барилгын ажлын газар шорооны ажлын үед тоосжилт үүсэх	Барилгын ажлын үед тоосжилт үүсэх газар шорооны ажлын үед усалгаа хийх	Барилгын ажлын талбай	Нэгж усалгаа	-	-	ҮАЗ	Барилгын ажил явагдах 4-9 сард усалгааг тогтмол хийх	Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS4585:2025. Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага MNS 5885-2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
2		Барилгын ажилд ашиглах элс, хайрга, цемент гэх мэт материалыг битүү орчинд хадгалах эсвэл хучиж тоосжилт үүсэхээс сэргийлэх	Барилгын материал хадгалах талбай	м²	-	-	ҮАЗ	Барилгын ажил явагдах үед	
3	Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаа агаарт тоосжилт үүсэх	Уурхайн олборлолтын үед зохиомол мананжуулагч, бодис ашиглан усалгаа хийх	Уурхайн ухаш, овоолгууд	ш	1	15.0	15.0	Үйл ажиллагааны турш	
4	Уурхайн дотоод тээврийн замаас тоосжилт үүсэх	Уурхайн дотоод тээврийн замын тогтмол маршрутыг төлөвлөж, шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх	Уурхайн дотоод зам	-	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	MNS4597:2014. Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага
5		Засаж сайжруулсан замаас өөр зам гаргахгүйн тулд	Уурхайн дотоод зам	ш	10	0.05	0.5	Жил бүрийн дотоод	

		MNS4597:2014. Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлагын дагуу тэмдэгжүүлэх, ухуулах самбар байршуулах ба бүрэн бүтэн байдлыг ханган ажиллах.						тээврийн замын төлөвлөлтөөс хамаарна.
6		Уурхайн дотоод тээврийн зам дагуу ачаатай үед 25-30км/цаг, хоосон үед 35-40км/цагийн хурдны хязгаарлалтыг хийн, хяналтыг тавих	Уурхайн дотоод зам	-	-	-	ҮАЗ	7 хоног бүр хурдны хяналтыг тавих
7		Уурхайн дотоод шороон замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор засвар арчилгааны тогтсон хуваарийг гаргаж, хуваарийн дагуу замыг засаж сайжруулах, нягтаршуулах	Уурхайн дотоод зам	-	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны турш Агаарын тухай хууль Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS4585:2025. MNS 5885-2008
8		Уурхайн дотоод тээврийн замд бороожуулагч болон бодис ашиглан усалгааг хийх	Уурхайн дотоод зам	км	Хөрс тээвэр 5.5 км, нүүрс тээвэр 8.3 км	1.0	13.8	Үйл ажиллагааны турш
9	Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас агаар бохирдуулагч	Тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрийн яндангаас орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хуваарийн дагуу хийж	Тээврийн хэрэгслүүд	-	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны турш MNS5013:2009. Бензин хөдөлгүүртэй автомашин MNS5014:2009. Дизель хөдөлгүүртэй автомашин – утааны тортогжилтын

	хийнүүд ялгарах	байх, утаа их ялгаруулдаг болон ашиглалтын хугацаа хэтэрсэн агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх машин, техникийг ашиглахгүй байх							зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
10	Дизель генераторын тулшний шаталтаас агаар бохирдуулагч хийнүүд ялгарах	Дизель генератораас ялгарах хорт хийг шүүх шүүлтүүр суурилуулах, шүүлтүүрийг заасан хугацаанд тогтмол солих	Дизель генератор	ш	2	0.5	1.0	2 жилд 1 удаа шүүлтүүрийг солих	MNS6757:2019. Автомашинны дизель хөдөлгүүрийг утааны тортгийн шүүлтүүр (DPF)-ээр тоноглох, ашиглах. Техникийн ерөнхий шаардлага
11	Усан халаалтын уурын зуухнаас агаар бохирдуулагч хийнүүд ялгарах	Усан халаалтын уурын зуухнаас ялгарах хорт хийг шүүх хүхэргүйжүүлэх шүүлтүүр суурилуулах, шүүлтүүрийг заасан хугацаанд тогтмол соли	Усан халаалтын уурын зуух	ш	3	5.0	15.0	5 жилд 1 удаа шүүлтүүрийг солих	MNS5919:2008. Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих нэгж
12	Шатахууны ууршилтаас NMVOC буюу метан биш дэгдэмхий органик бохирдуулагч	ШТМ-ын агуулахын орчимд анхааруулах болон таниулах тэмдгийг байршуулах, агуулахын ажилчид шатахуун түгээх станцад хуваарь гарган үзлэг хийх, дутагдал	ШТС, ШТМ- ын агуулах	-	-	-	YAZ	Үйл ажиллагааны турш	MNS4628:2013. Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага MNS3015:2014. Шатахуун түгээгүүр. Шалгах арга хэрэгсэл

	бодис ялгарч болзошгүй	илэрсэн тохиолдолд засах арга хэмжээг авч хэрэгжүүлэх							
13	Нүүрс хуурай баяжуулах үйлдвэрийн тоосжилт	Нүүрс хуурай баяжуулах үйлдвэрийн тоос баригчийн хэвийн ажиллагааг хангаж, үйлдвэрлэгчийн заасан хугацаанд засвар үйлчилгээг хийх	Нүүрс баяжуулах үйлдвэр				ҮАЗ	Үйл ажиллагааны турш	
14	Нүүрсний агаартай харьцах, хүчилтөрөгчтэй удаан хугацаанд исэлдэх, дулаан хуримтлагдсаны дүнд өөрөө шатах	Агаарын найрлага дахь СО, СО ₂ , СН ₄ , хүчилтөрөгчийн түвшинг тогтмол хэмжих. СО ихсэх нь өөрөө шаталтын анхны шинж тэмдэг гарч буй эсэхийг хянахын тулд овоолго, агуулахад термометр, дулааны мэдрэгч суурилуулж хяналт тавих.	Нүүрсний овоолго	-	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	
Хөрсөн бүрхэвч, газрын гадарга									
15	Төслийн үйл ажиллагаагаар 3,738.7 мян.м ³ шимт хөрс хуулна.	Олборлолт болон бусад үйл ажиллагаа явагдах талбайн шимт хөрсийг зохистой зузаанаар хуулж тусад нь хадгалах	Төслийн талбай	га	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	MNS5916:2008. Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
16		Шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг MNS 5916:2008 стандартын дагуу хуулж, хадгалах ба удаан хадгалсан хөрс сийрэгжих тул хөрсний овоолгуудын дээд болон	Хөрсний овоолгууд	овоолго	4	-	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	

		хажуу гадаргууг хэлбэржүүлэлт хийж, олон наст өвслөг ургамал тарьж, шимт хөрсийг салхинд хийсэн, усанд урсах, бохирдох зэргээс хамгаалах						
17		Хөрсний овоолгуудын ойр орчимд тэмдэг тэмдэглэгээг хийх	Хөрсний овоолгууд	овоолго	4	0.05	0.2	1,3 дах жилд
18		Хөрсний овоолгуудын талбайн хэмжээ, байршил зэргийг тусган бүртгэл хөтлөх.	Хөрсний овоолгууд	овоолго	4	-	ҮАЗ	Үйл ажиллагаа
19	Төсөл үйл ажиллагааны улмаас нийт 1,626.7 га талбай эвдрэлд өртөнө.	Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн хэмжээнд эвдрэлд өртөх 1,626.7 га талбайг байгалийн бүтэц онцлогт нь нийцүүлэн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийх.	Төслийн талбай	га	Нөхөн сэргээлт хаалтын төлөвлөгөөнд тусгав.	Техникийн нөхөн сэргээлтийг жил бүр гүйцэтгэнэ.	MNS5917:2008. Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS5918:2023. Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага	
20		Эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх	Төслийн талбай	га	Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав.	Үйл ажиллагааны турш	Газрын тухай хуулийн 56.6-р зүйл Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-р зүйл	

21	Хүнд машин механизм, машин техникийн аюулгүй ажиллагаа алдагдах, осол эрсдэл болох хүний санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас ШТМ асгарч, улмаар хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.	Машин техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, тээвэрлэлтийн үед шатах тослох материал асгарахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих, асгаралт болсон тохиолдолд авах арга хэмжээний дотоод журмыг боловсруулах	Төслийн талбай	-	-	-	ҮАЗ	Эхний жил журмыг боловсруулж, үйл ажиллагааны турш ажилчдад таниулан даган мөрдөнө.	MNS5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
22	алдагдах, осол эрсдэл болох хүний санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас ШТМ асгарч, улмаар хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.	Асгаралтын үед шуурхай арга хэмжээ авах, асгаралтын иж бүрдлийг уурхайн бүсэд асгаралт гарч болзошгүй газруудад байрлуулах	Засварын газар, 2 ШТС, Баяжуулах үйлдвэр, Зогсоолууд	Багц	8	1.5	12.0	Эхний жил	
23	Химийн бодисын асгаралт, алдагдал үүссэн тохиолдолд хөрсөн бүрхэвч	Шатахуун түгээх станц, агуулахыг байнгын хяналтад байлгаж, гэмтэл гарсан тохиолдолд түргэн шуурхай засварлах ба хяналтын бүртгэл хөтөлж, тогтмол үзлэг хийх.	ШТС, Тэсрэх материалын агуулах	удаа	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны турш сард 1-2 удаа	MNS4628:2013. Шатахуун түгээх станц. Техникийн ерөнхий шаардлага MNS3015:2014. Шатахуун түгээгүүр. Шалгах арга хэрэгсэл
24	Химийн бодисын асгаралт, алдагдал үүссэн тохиолдолд хөрсөн бүрхэвч	Химийн бодис материалыг холбогдох журам болон хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу тээвэрлэлт, хадгалалтын нөхцөлийг нарийн баримтлан ажиллах	Химийн бодис тээвэрлэлтийн зам, химийн бодисын агуулах	удаа	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль MNS6458:2014. Химийн хорт бодис бүтээгдэхүүний агуулах, ерөнхий шаардлага

	бохирдож болзошгүй.								
25	Хог хаягдлыг стандарт шаардлага хангаагүй нөхцөлд хадгалсан тохиолдолд ойр орчмын хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.	Зориулалтын бүс талбайд хог хаягдал хаяж хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, хог хаягдлын дотоод журмыг боловсруулан ажиллах. Энгийн ба аюултай хог хаягдлыг зохих журмын дагуу эх үүсвэр дээр нь ангиан ялгаж, хадгалан, хог хаягдлыг тогтмол эрх бүхий байгууллагаар ачиж тэвэрлүүлэх.	Төслийн талбай	-	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль
Усан орчин									
26	Ил уурхайн олборлолтын улмаас ил уурхай 1-т 45 л/с, ил уурхай 3 т 1 л/с усны шүүрэлт үүснэ.	Уурхайн талбайн бүс нутагт газрын доорх усны хайгуул, судалгааны ажлыг усны эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулах.	Төслийн талбай	удаа	1	-	ҮАЗ	1 дэх жилд	Усны тухай хууль
27	Төслийн үйл ажиллагааны хүрээнд 79.55 л/с ус ашиглана.	Ашиглах усны хэмжээгээр ус ашиглах гэрээ байгуулан, ус ашиглах болон хаягдал усны дүгнэлтийг жил бүр гаргуулан ажиллах.	Төслийн талбай	удаа	5		ҮАЗ	Жил бүр	Усны тухай хуулийн 28, 29, 30-р зүйл

28	Ус ашиглах гэрээ, боломжит нөөцийн дүгнэлтэд заасан ашиглах хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх тухай үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, усыг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглах зарчим боловсруулж даган мөрдөж ажиллах.	Төслийн талбай	-	-		ҮАЗ	Үйл ажиллагааны турш	
29	Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах бөгөөд шугам хоолой бүрийн тоолуурын баталгаажуулалт, түүний хяналтыг хийх	Төслийн талбайн уст цэгүүд	ш	8	0.5	4.0	Эхний жил	Усны тухай хуулийн 30.1.4-р зүйл
30	Дэлхийн усны өдөрлөгөөр уурхайн хүрээнд усны хэрэглээг бууруулах, ариг гамтай ашиглах талаар уурхайн нийт ажилчдад сургалт зохион байгуулж, хэрэгжилтийг хянах.	Төслийн ажилчид	удаа	1	1.0	1.0	Жил бүр 1 удаа	
31	Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн ус ашиглалт, хаягдал ус хаях зайлуулахтай холбоотой мэдээллийг усны нэгдсэн	Сэкер Ресурсус Монголиа ХХК	-	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	

		мэдээллийн системд бүртгүүлэх							
32	Химийн бодисууд, ШТМ зэрэг хор аюул бүхий бодис материалууд осол эрсдэл, хүний санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас асгарсан тохиолдолд усан орчныг бохирдуулах.	Аадар бороо, шар усны үерийн ус зайлуулах суваг, шуудуу, далангийн технологийн дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэх, үерийн усаар бохирдол зөөгдөхөөс сэргийлэх.	Төслийн талбай	-	-	-		Үйл ажиллагааны турш	MNS AASHTO M86:2005 Бетонон суваг, үерийн ус зайлуулах хоолой. Техникийн шаардлага
33	Бохир усны цэвэршүүлэлт стандарт шаардлагад нийцээгүй үед усан орчин бохирдох	Төслийн талбайн хэмжээнд байрлах уст цэгүүд, цооногуудаас дээж авч тогтмол хяналт шинжилгээ хийлгэх, хүлцэх хэмжээнээс давсан тохиолдолд эх үүсвэр, шалтгааныг тодорхойлж бууруулах арга хэмжээг авах	Төслийн талбайн уст цэгүүд	ш	8		Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.	Жил бүр	MNS 0900:2018. Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS6148:2010. Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
34	Бохир усны цэвэршүүлэлт стандарт шаардлагад нийцээгүй үед усан орчин бохирдох	Хаягдал ус цэвэрлэх байгууламжаас байгуулж, хаягдал бохир усны найрлагыг MNS4943:2015 стандартад заасан шаардлагад нийцүүлж цэвэрлэх, саарал усыг дахин ашиглах	Төслийн талбайн цэвэрлэх байгууламж	ш	1	-	ХОЗ	Эхний жил	MNS 4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага

35		Хаягдал дамжуулах хоолой, ажилчдын бохир ус цэвэрлэх байгууламж, химийн бодисын агуулахын бүрэн бүтэн байдлыг хянах, хуваарийн дагуу үзлэг шалгалт хийх	Төслийн талбайн цэвэрлэх байгууламж, химийн бодисын агуулах	удаа	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны турш сард 1-2 удаа	
36		Хаягдал усны тоо хэмжээ, найрлагад хяналт тавьж, шинжилгээ хийлгэх	Төслийн талбайн цэвэрлэх байгууламж,	ш	1	Орчны шинжилгээний хөтөлбөрт тусгав.	хяналт	Жил бүр	Усны тухай хууль Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
Ургамлан нөмрөг									
37	Төслийн үйл ажиллагаагаа р 1,626.7 га талбай эвдрэлд өртөж, шимт хөрсийг хуулснаар ургамлан нөмрөг устгах	Аливаа газар хөндөлт бүрийн өмнө тухайн талбайн ургамлан нөмрөгийн суурь мэдээллийг цуглуулж, нөхөн сэргээлтийн ажилд аль болох тухайн нутгийн ургамлын үрүүдийг ашиглаж, байгалийн бүлгэмдлийг дахин сэргээх арга хэмжээ авах.	Төслийн талбай	удаа	-	Орчны шинжилгээний хөтөлбөрт тусгав.	хяналт	Жил бүр	Байгалийн ургамлын тухай хууль Ургамал хамгааллын тухай хууль
38		Уурхайн ерөнхий төлөвлөгөө, зураг төслийн дагуу гүйцэтгэх, төлөвлөлтийн бус газар хөндөхгүй байх.	Төслийн талбай	-	-	-	ХОЗ	Үйл ажиллагааны турш	
39		Төслийн барилга байгууламжийн барилгын ажил дууссаны дараа барилгын ажлаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээж, тухайн орчны 10-иас	Төслийн талбай	га	6.5	Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав.		Үйл ажиллагааны турш	Газрын тухай хуулийн 56.6-р зүйл Хөрм хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-р зүйл

		багагүй хувьд ногоон байгууламж байгуулах.							
40	Төслийн үйл ажиллагааны үед үүсэх тоосжилтын нөлөөгөөр тухайн хэсгийн ургамлуудын физиологийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж доройтох	Уурхайн ажилчдад төсөлд тусгасан зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ургамлан нөмрөг доройтуулахгүй байх талаар анхааруулга сануулга өгөх, МУ-ын улаан ном, Бүс нутгийн болон олон улсын улаан дансанд бүртгэлтэй, олон улсын гэрээ, конвенцоор хамгаалагдсан ховор, нэн ховор ургамлын талаарх мэдээллийг нийт ажилтан, гэрээтүүд болон нутгийн иргэдэд мэдээлж, хамгааллын талаар сургалт, сурталчилгаа хийж байх.	Төслийн ажилчид	удаа	1	1.0	1.0	Жил бүр 1 удаа	Байгалийн ургамлын тухай хууль Ургамал хамгааллын тухай хууль
41		Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянхонгор аймгийн БОАЖГ-тай хамтран ажиллаж, төслийн хугацаанд аймгийн урт хугацааны төлөвлөлттэй уялдуулах.	Төслийн талбай	га	6.5	Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав.		Үйл ажиллагааны турш	МУ-ын ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлиг
Амьтны аймаг									

42		Зуд болон ган гачигтай үед зэрлэг ан амьтдад өвс, тэжээл, хужир, мөс тавьж өгөх зэргээр ан амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ авах	Төслийн талбайн ойр орчимд	удаа	1	2.0	2.0	1,3,5 дах жилд	
43	Уурхайлалд өртөх талбайн хэмжээгээр биологийн олон янз байдлын амьдрах орчин доройтох, амьдрах орчноосоо дайжих	Ажилчдын хууль бус ан агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байхад хяналт тавих, сургалт явуулах, ан амьтан агнасан тохиолдолд хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх.	Төслийн ажилчид	удаа	1	1.0	1.0	Жилд 1 удаа	Амьтны тухай хуулийн 6-р зүйл
44		Амьтдын идэш тэжээл эрж хайх, нүүдэллэх зам харгуй, нүх оромжийн ойролцоо анхааруулсан тэмдгүүд байрлуулах	Төслийн талбай болон түүний ойр орчимд	ш	10	0.05	0.5	Эхний жил	MNS4597:2014. Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага
45		Төслийн талбай болон түүний ойр орчимд зэрлэг амьтдын зүйл, нягтшилыг үнэлэх зорилгоор автомат камер суурилуулах, зэрлэг амьтны тархац, нөөцийг үнэлэх зорилгоор шугаман замналын судалгаа хийх, шувуудын судалгаа, махчин шувуудын үүрний байршилыг тогтоох зэргээр хяналт мониторингийн ажлыг гүйцэтгэх	Төслийн талбай	ш	-		Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.	Үйл ажиллагааны турш	Амьтны тухай хууль

46	Дотоод болон гадаад тээврийн зам нь зэрлэг амьтдын амьдрах орчныг доройтуулах, хуваагдал үүсгэх	Уурхайн ажилчдад тогтоосон зам харгүйгээс бусад газраар машин техник хэрэгслээр явж ойр орчмын амьтдыг үргээхгүй байх талаар сануулга өгөх, ан амьтны талаарх мэдээллийг нийт ажилтанд мэдээлж, сургалт, сурталчилгаа хийх, уурхайн бүсэд зэрлэг амьтан нэвтэрсэн тохиолдолд хариуцах албанд хэрхэн мэдэгдэх журамтай байх	Төслийн ажилчид	удаа	1	1.5	1.5	Жилд 1 удаа	Амьтны тухай хуулийн 6-р зүйл
Нийт							68.5		

ҮАЗ - Үйл ажиллагааны зардалд тусгах, ХОЗ – Хөрөнгө оруулалтын зардалд тусгах

6.2 Ногоон байгууламжийн төлөвлөгөө

Монгол орон даяар Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигаар Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах Монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж байгаа билээ. Төсөл хэрэгжүүлэгч нь энэхүү хөдөлгөөний хүрээнд Засаг даргын тамгын газартай харилцан тохиролцсоны үндсэн дээр сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор хамтран ажиллаж, орон нутгийн онцлогт тохирсон мод бутыг тарьж байгаа билээ. Иймд үргэлжлүүлэн тухайн жил бүр сумаас ирсэн саналын дагуу үргэлжлүүлэн хамтран ажиллана.

Хүснэгт № 3 Ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Гүйцэтгэх ажил	Хэмж их нэгж	Тоо хэмжэ э	Нэгжи йн зардал, мян.тө г	Зардал, сая.төг	
					I	Нийт
1	Ногоон байгууламжийн усалгаа, тордлогоо хийх	Мод, ургамлыг услах, нөхөн тарилт хийх.	ш	1000	ҮАЗ	ҮАЗ
<i>Нийт</i>						

ҮАЗ - Үйл ажиллагааны зардалд тусгах.

6.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслөөс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд Сэгс цагаан богд уул орчмоос 2 бодгаль цоохор ирвэс барьж хүзүүвч зүүх замаар түүний биологи, экологийн судалгааг хийх, нүүдэл шилжилт хөдөлгөөнийг судалснаар хамгааллын менежментийг сайжруулах боломжтой. Цоохор ирвэсийг манай оронд Тост тосон бумбын нуруунд, Монгол Алтай болон Говь-Алтайн салбар уулсаар барьж хүзүүвч зүүхдээ хавар, эсвэл намрын улирал илүү тохиромжтой байдгийг онцолсон байна. Иймд хавар 3-4 сар, намар 9-11 сард амьтан барих нь хамгийн тохиромжтой бөгөөд амьтны тухай хуулийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас амьтан барих зөвшөөрөл авахаас гадна амьтны мэргэжлийн байгууллагыг оролцуулах журамтай.

Энэхүү БОННУ нэмэлт тодотгол тайланд төсөл хэрэгжих эхний 5 жилийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг нарийвчлан боловсруулсан ч төсөл нь 10 жил үргэлжлэх тул эхний 5 жилд гүйцэтгэсэн цоохор ирвэсийн судалгаанууд дээр үндэслэн цаашид урт хугацаандаа биологийн олон янз байдлын хамгааллын менежментийг хэрэгжүүлж, ойн зурвасыг арчлах тордох, нэмэгдүүлэх үйл ажиллагааг төлөвлөн үргэлжлүүлбэл илүү үр дүнтэй.

Хүснэгт № 4 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зорилго	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Дүйцүүлэн хамгааллын байршил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Зардал, сая.төг	
							I жил	Нийт
Цоохор ирвэсийг хамгаалах хөтөлбөр								
1	Хамгаалах зүйл, популяцийн тоо хэмжээ, аль нэг экологийн чухал хүчин зүйлийг сайжруулах нөхөн сэргээх	Цоохор ирвэсийн биологи, экологийн болон нүүдэл шилжилт хөдөлгөөн, тархац газрын судалгаа хийх	Сэгс цагаан богд	судалгаа	1	45	45	45
Ойн зурвас байгуулах								
2	Хамгаалах зүйлийн одоогийн амьдрах орчныг сайжруулах, нөхөн сэргээх	Талбайг бэлтгэх (усан хангамж, хашаа)	Баянхонгор аймаг, Шинэжинст сум	га	10	-	136	136
Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт								
3	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт	Баянхонгор аймаг	удаа	1	10	10	10
Нийт						191.000.000		

6.4 Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанд эдэлбэр газрыг ашигласнаар материаллаг болон эдийн засгийн шилжилт үүсдэг. Материаллаг шилжилт гэдэг нь айл өрх, тэдний өмч хөрөнгө (өвөлжөө, бууц, худаг), эзэмшлийг нүүлгэн шилжүүлэхийг хэлэх бөгөөд төслийн талбай дотор амьдардаг айл өрхүүдийг нүүлгэх үйл ажиллагаа юм. Эдийн засгийн шилжилт гэдэгт айл өрхүүд, тэдний мал сүрэг хуучин бэлчрээсээ, худаг уснаасаа алслагдаж нүүхийг хэлнэ. Хотгорын чулуун нүүрсний ордын лицензийн талбайд давхцалтай газар эзэмших эрхтэй 9 айл байна.

Төслийн нөлөөлөлд өртөж буй иргэн, айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох амьдралын түвшин, амьжиргааг бууруулахгүй дээшлүүлэх боломжийг бүрдүүлэн, харилцан тохиролцон ажиллах ажиллагааг явуулах шаардлагатай бөгөөд эдгээр нь дараах үндсэн зарчмуудыг баримталбал зохистой.

Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнээс боломжит бүхий л байдлаар зайлсхийхийг эрмэлзж, зайлшгүй нөхцөлд нүүлгэн суурьшуулалт хийгдэх шийдвэрийг төслийн нөлөөлөлд өртөх иргэд, өрх, аж ахуйн нэгжийн оролцоотой шийдвэрлэх бөгөөд төслийн талбайн нөлөөллийн бүсэд хамрагдаж буй иргэн, айл өрхийн газрын өмчлөл, эзэмшил, ашиглалтын байдал түүнд төслийн үйл ажиллагаанаас үүдэн газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх шаардлага зэргийг нарийвчлан тусгасан төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох шаардлагатай.

Хүснэгт № 5 Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Гүйцэтгэх ажил	Нэгжийн зардал, сая.төг	Зардал, сая.төг	
			I жил	Нийт
I	Нүүлгэн шилжүүлэлтийн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах	Шууд нөлөөлөлд өртөх айл өрхүүдийг нарийвчлан тодорхойлох	15.0	15.0
Нийт			15,000,000	

ҮАЗ - Үйл ажиллагааны зардалд тусгах.

6.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайн археологийн авран хамгаалах малтлага судалгааг 2012 онд Шинжлэх ухааны академийн археологийн хүрээлэн хийж гүйцэтгэсэн бөгөөд уг судалгаагаар нийт 5 дурсгалыг малтан судалж, нөхөн сэргээж, тэмдэглэн баримтжуулалт хийсэн байна. Харин төслийн талбайн палеонтологийн нөөц баялгийн үнэлгээг 2023 онд Шинжлэх ухааны академийн палеонтологийн хүрээлэн хийж гүйцэтгэсэн бөгөөд судалгааны үед эртний амьтан ургамлын үлдвэр илрээгүй байна. Төсөл хэрэгжүүлэгч “Сэкер Ресурсус Монголиа” ХХК нь уурхайн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн дурсгал болон олдвор санамсаргүй байдлаар олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т заасны дагуу ажлаа зогсоож, энэ тухай сумын Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэж, арга хэмжээ авна.

6.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

“Сэкер Ресурсус Монголиа” ХХК нь Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр төслийн үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллахаар төлөвлөсөн.

Энгийн хог хаягдал:

Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь дахин ашиглах (төмөр, мод, резин), дахин боловсруулах (хүнсний хог хаягдал, хуванцар, цаас, шил, лааз гэх мэт), бусад дахин ашиглагдахгүй хог хаягдал гэж 3 төрлөөр ангилан ялгана:

- Дахин ашиглах хог хаягдлыг засаж янзлан дахин ашиглах эсвэл орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй хүмүүст хандивлах.
- Дахин боловсруулах хог хаягдлыг орон нутгийн дахивар авдаг газартай гэрээ байгуулан хүргүүлэх. Мөн хүнсний хог хаягдлыг бордоо үйлдвэрлэдэг төсөл хөтөлбөр, байгууллагатай хамтран ажиллаж, хүнсний хог хаягдлаа өгөх, бордоо хийж туршин, ногоон байгууламжид ашиглах.
- Бусад дахин боловсруулах боломжгүй хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тогтсон хугацаанд тээвэрлүүлэх.

Аюултай хог хаягдал:

Машин техникийн шатах тослох материал асгарсан тохиолдолд болон аливаа осол эрсдэл, химийн бодисын сав баглаа боодол зэргээр аюултай хог хаягдал үүсэж болзошгүй. Иймд аюултай хог хаягдал түр хадгалах тусгай зориулалтын шаардлага хангасан цэг байгуулж, аюултай хог хаягдлыг хадгалах сав нэг бүрийг “Аюултай хог хаягдал” гэсэн нэр, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээ байршуулж, ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна. Аюултай хог хаягдлыг Аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах, эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлж устгуулна.

Хүснэгт № 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Зардал, сая.төг	Нийт зардал сая.₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
							I жил			
1		2	3	4	5	6	7	8	9	10
1		Уурхайн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгаа хийх	Төслийн талбай	удаа	1	20.0	20.0	20.0	Эхний жил	Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйл (Шинэчилсэн найруулга), Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
2	Энгийн хог хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулах зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй хогийн савыг төслийн талбайд байршуулах	Төслийн талбай	ш	1	5	5	5	Эхний жил	Хог хаягдлын тухай хуулийн 4-р бүлэг БОАЖ-ын сайдын 2018 оны 11-р сарын 17 өдрийн А/443-р тушаалын хавсралт Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага
2		Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг аймгийн хог хаягдал дахин боловсруулах	Төслийн талбай	удаа	5	-	ҮАЗ	ҮАЗ	Жилд 1-2 удаа	

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Зардал, сая.төг	Нийт зардал сая.₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
							I жил			
1		2	3	4	5	6	7	8	9	10
3		төсөл хөтөлбөр, үйлдвэрт нийлүүлэх								
		Бусад хог хаягдлыг гэрээт ААН-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Төслийн талбай	удаа	12	0.04	0.48	0.48	Сард 1 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.4-р зүйл, 4-р бүлэг
4		Батлагдсан маягт болон “эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ тухай бүр хөтөлж, журмаар тогтоосон хугацаанд сумын Засаг даргад хүргүүлэх	Сэкер Ресорсус Монголиа ХХК	Нэгж тайлан	5	-	ҮАЗ	ҮАЗ	Тухай бүрд нь хөтөлж, жил бүрийн 12-р сарын 15-с өмнө тайлан мэдээг гарган хүргүүлэх.	БОНХЯ-ны 2018 оны А/428 дугаар тушаал Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Зардал, сая.төг	Нийт зардал сая.₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
							I жил			
1		2	3	4	5	6	7	8	9	10
5		Төслийн талбай орчмын эргэн тойронд 50 м зайд цэвэрлэгээ хийх	Төслийн талбай	удаа	ҮАЗ	ҮАЗ	ҮАЗ	ҮАЗ	Сар бүр	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.10-р зүйл
6	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж эх үүсвэр дээр түр хадгалах цэг байгуулах, төслийн талбайд зориулалтын савыг байрлуулан, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Төслийн талбай	ш	1	10.0	10.0	10.0	Эхний жил	Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг
7		Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, хадгалах шилжүүлэх үйл ажиллагаанд байнгын хяналтыг тавьж, бүртгэл хөтлөх	Сэкер Ресорсус Монголиа ХХК	-	-	-	ҮАЗ	ҮАЗ	Сард 1 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 28 дугаар зүйл

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Зардал, сая.төг	Нийт зардал сая.₮	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
							I жил			
1		2	3	4	5	6	7	8	9	10
8		Хэвийн үйл ажиллагааны үед аюултай хог хаягдалтай харьцах болон аюул ослын үед ажиллах зааварчилгааг түүнтэй харьцдаг ажилтан бүрд сургаж, дадлагажуулах	Аюултай хог хаягдалтай харьцах ажилчид	Нэгж сургалт	-	1.0	1.0	1.0	Жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг
9		Аюултай хог хаягдал тээвэрлэх, устгах эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан аюултай хог хаягдлыг тээвэрлүүлэх, устгуулах	Төслийн талбай	кг	-	Химийн бодисын шуудай 900₮ Хуванцар сав 1180₮	ҮАЗ	ҮАЗ	Жилд 4 удаа	
Нийт						36,480,000				
ҮАЗ - Үйл ажиллагааны зардалд тусгах.										

6.7 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Сэкер Ресорсус Монголиа ХХК нь гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлсон ба эрсдэлүүдийг бууруулах, арилгах үүднээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн гүйцэтгэж ажиллахаар төлөвлөгөөг боловсрууллаа.

Хүснэгт № 7 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй аюул, осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.₮	Зардал, жилийн задаргаа сая ₮	Нийт зардал, сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
							I жил			
1		2	3	5	6	7	8	9	10	11
1	Байгалийн гамшигт үзэгдэл	Уурхайд онцгой байдал, осол эрсдэлийн үед “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулан, жил бүр сайжруулж мөрдөн ажиллах	Сэкер Ресорсус Монголиа ХХК	Нэгж төлөвлөгөө	1	-	ҮАЗ	ҮАЗ	Гамшгийн эрсдэлийн үнэлгээг 3 жилд 1 удаа хийлгэх ба үйл ажиллагааны турш даган мөрдөнө.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Гамшгаас хамгаалах тухай хууль
2		Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллагаар сургалт зохион байгуулуулж, ажилчдыг дадлагажуулах	Сэкер Ресорсус Монголиа ХХК	Нэгж сургалт	1	2.0	2.0	2.0	Жилд 1 удаа	

№	Гол болон болзошгүй аюул, осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.₮	Зардал, жилийн задаргаа сая.₮	Нийт зардал, сая.₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
							I жил			
	1	2	3	5	6	7	8	9	10	11
3		ОБЕГ-ын мэдээ болон цаг агаарын станцын мэдээг тогтмол хянаж үйл ажиллагаанд харгалзан үзэж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, дохиог хүмүүст дамжуулан анхааруулга өгч байх	Сэкер Ресорсус Монголиа ХХК	-	-	-	ҮАЗ	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	
4		Төслийн үйл ажиллагаанд ашиглах барилга байгууламжийг стандартын дагуу барин улсын комисст шалгуулан ашиглалтад оруулах	Сэкер Ресорсус Монголиа ХХК	-	-	-	ХОЗ	ХОЗ	Бүтээн байгуулалтын үед	
5		Төслийн үйл ажиллагаанд ашиглах барилга байгууламжийг стандартын дагуу	Сэкер Ресорсус Монголиа ХХК	-	-	-	ХОЗ	ХОЗ	Бүтээн байгуулалтын үед	

№	Гол болон болзошгүй аюул, осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.₮	Зардал, жилийн задаргаа сая ₮	Нийт зардал, сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
							I жил			
1		2	3	5	6	7	8	9	10	11
5		барин улсын комисст шалгуулан ашиглалтад оруулах								
		Үерийн аюулаас сэргийлэхийн тулд ус зайлуулах үерийн усны суваг шуудууг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх бүрэн бүтэн байдлыг хянах, үзлэг шалгалтуудыг тогтмол явуулж байх	Төслийн талбай	-	-	-	ХОЗ	ХОЗ	Бүтээн байгуулалтын үед	
		Төслийн талбайд аянга, цахилгаан газардуулах тоноглолуудыг байгуулах, бүрэн байдал болон газардуулгын эсэргүүцлийн хэмжилт хийлгэж байх	Төслийн талбай	-	-	-	ХОЗ	ХОЗ	Бүтээн байгуулалтын үед	
7		Газар хөдлөлийн аюулын үед авах арга	Сэкер Ресорсус	Нэгж сургалт	1	1.0	1.0	1.0	Жилд 1 удаа	

№	Гол болон болзошгүй аюул, осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.₮	Зардал, жилийн задаргаа сая ₮	Нийт зардал, сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
							I жил			
1		2	3	5	6	7	8	9	10	11
		хэмжээний төлөвлөгөөний талаарх мэдлэг өгөх сургалт хөтөлбөр, турших сургуулилтнуудыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах	Монголиа ХХК							
8	Гал түймэр	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж төслийн талбайд байршуулах, гал унтраах хэрэгслийн хэвийн үйл ажиллагаанд үзлэг шалгалт тогтмол хийх	Төслийн талбай	ш	5 ш галын сараа 15 ш галын хор	галын сарааны багц 1.0 галын хор 0.1	13.0	13.0	Үйл ажиллагааны турш	Галын аюулгүй байдлын тухай хууль MNS5566:2020. Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
9		Галын аюулын талаар анхааруулга самбар, аваарын гарц, барилгын зохион байгуулалт зэргийг эзэмшлийн объект	Төслийн талбай	ш	15 ш самбар	Галын самбар 0.1	1.5	1.5	Бүтээн байгуулалтын үед	

№	Гол болон болзошгүй аюул, осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.₮	Зардал, жилийн задаргаа сая ₮	Нийт зардал, сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
							I жил			
1		2	3	5	6	7	8	9	10	11
10		бүрд онцлогийг тусган тавих								MNS4244:1994. Хөдөлмөр хамгааллын систем Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS0639:2016. Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж болон тээврийн хэрэгслийн нэр томьёо ба тодорхойлолт
		Гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллагсдад мэргэжлийн байгууллагын тусламжтай сургалт зохион байгуулах	Сэкер Ресорсус Монголиа ХХК	Нэгж сургалт	1	1.0	1.0	1.0	Жилд 1 удаа	
11	Үйл ажиллагааны осол гэмтэл	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Төслийн ажилчид	Иж бүрдэл	-	-	ҮАЗ	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	MNS6654:2017. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хувийн хамгаалах

№	Гол болон болзошгүй аюул, осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.₮	Зардал, жилийн задаргаа сая ₮	Нийт зардал, сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
							I жил			
1		2	3	5	6	7	8	9	10	11
										хувцас хэрэгсэл. Амьсгал хамгаалах хэрэгслийн сонголт, хэрэглээнд тавих ерөнхий шаардлага MNS ISO13688:2000. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага
12		Бүх ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Төслийн ажилчид	Нэгж сургалт	-	-	ҮАЗ	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль

№	Гол болон болзошгүй аюул, осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.₮	Зардал, жилийн задаргаа сая ₮	Нийт зардал, сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
							I жил			
1		2	3	5	6	7	8	9	10	11
13	Автомашинны осол авар	Замын хөдөлгөөний аюулгүйн дүрмийг мөрдүүлж ажиллах	Тээврийн жолооч нар	Нэгж сургалт	-	-	ҮАЗ	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	Замын хөдөлгөөний дүрэм, Замын аюулгүй байдлын тухай хууль
14	Химийн бодис	Химийн бодисыг хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу хадгалах, тээвэрлэх, ашиглах	Сэкер Сэкер Ресорсус Монголиа ХХК	-	-	-	ҮАЗ	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	Монгол Улсын Шадар сайд, БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалын хавсралт Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх,
15		Химийн бодис хадгалах агуулахын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж ажиллах, химийн бодис хадгалж буй агуулахын агааржуулалтын системийг хэвийн ажиллаж буй эсэхэд хяналт тавих	Сэкер Ресорсус Монголиа ХХК	-	-	-	ҮАЗ	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	
16		Химийн бодис хадгалах, ашиглах үед	Сэкер Ресорсус	Нэгж сургалт	1	1.0	1.0	1.0	Жилд 1 удаа	

Гол болон № болзошгүй аюул, осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.₮	Зардал, жилийн задаргаа сая.₮ I	Нийт зардал, сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	5	6	7	8	9	10	11
	химийн бодис асгарсан, алдагдсан, гал түймэр гарснаас үүсэж болзошгүй аюул, ослын үед ажиллах дүрэм журмыг боловсруулан, жил бүр ажилчдад таниулан, дагаж мөрдөх	Монголиа ХХК							ашиглах, устгах журам MNS4992:2000
17	Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, саармагжуулах асгаралтын иж бүрдлийг бэлэн байлгах (элс, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, хүрз, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болог тууз зэрэг)	Төслийн талбай	иж бүрдэл	5 ш иж бүрдэл	Иж бүрдэл 1.0	5.0	5.0	Үйл ажиллагааны турш	

Гол болон № болзошгүй аюул, осол	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.₮	Зардал, жилийн задаргаа сая ₮ I	Нийт зардал, сая ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	5	6	7	8	9	10	11
<i>Нийт</i>								24,500,000	

ҮАЗ - Үйл ажиллагааны зардалд тусгах, ХОЗ – Хөрөнгө оруулалтын зардалд тусгах

6.8 Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

“Сэкер Ресурсус Монголиа” ХХК-ийн Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдврийн үйл ажиллагааны явцад байгаль хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбоотой арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлэх шаардлагатай. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны төлөвлөгөөт аудитыг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэх нь зүйтэй.

Хүснэгт № 8 Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
1	2	3	4	
1	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жилд нэг удаа	Удирдлага, БОМ, ХАБЭА
2	Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, сургалт аян, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүр нэг удаа	БОМ
3	Төслийн талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагаар хийлгэж байх	Үйл ажиллагааны зардалд тусгах	5 жил тутамд нэг удаа	Удирдлага, БОМ
Нийт			ҮАЗ	

6.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах болон баяжуулах үйлдвэр төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг төсөл хэрэгжүүлэгч Сэкер Ресурсус Монголиа ХХК-д өгөгдсөн. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна. Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад Сэкер Ресурсус Монголиа ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан

үнэлгээ хийх аргачлал"-ийн 4-р хэсэг болох Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав. Төслийн хүрээнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг дотоод хяналт шинжилгээ, гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээ, хамтын оролцоотой хяналт шинжилгээ гэсэн 3 хэлбэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

- Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр: Төсөл хэрэгжүүлэгч төслөөс бий болж буй үр дагавруудыг хянах, илрүүлэх зорилгоор төслийн талбайд агаар, хөрс, усны шинжилгээг улиралд 1 удаа жилд 1 удаа байхаар хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлэх.
- Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр: Хөндлөнгийн хяналт шинжилгээний мэргэжлийн байгууллагаар орчны хяналт шинжилгээг жилд 1-2 удаа хийлгэх, дотоод хяналт шинжилгээтэй харьцуулах, дүгнэх
- Хамтын оролцоотой хяналт шинжилгээний хөтөлбөр: Орон нутгийн иргэдтэй хамтран уурхайн ойр орчмын усны эх үүсвэр, хөрсний дээж цуглуулах, агаарын хэмжилт хийх, үр дүнг тайлагнах ажилд татан оролцуулах

6.9.1 Дуу чимээний хяналт шинжилгээний хөтөлбөр

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээнд үзүүлж буй нөлөөллийг хянах, илрүүлэх зорилгоор дуу чимээ үүсгэж буй эх үүсвэр бүр дээр хяналтын цэгүүд төлөвлөж, байнгын хяналт шинжилгээ хийх шаардлагатай.

Дуу чимээний хяналт мониторинг хийх үзүүлэлтүүд - Төслийн хүрээнд барилгын ажил, тээвэрлэлт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа зэргээс дуу чимээний нөлөөлөл үзүүлэх ба тухайн нөлөөлөл үзүүлэгч эх үүсвэр тус бүр дээр дуу чимээний хэмжилтийг хийнэ. Дуу, шуугиан нь орчинд тархахдаа эргэн тойрондоо даралт эсвэл нягтын үечилсэн өөрчлөлтийг бий болгодог.


Хүснэгт № 9 Дуу чимээний хэмжилтийн үр дүнгийн харьцуулалт (MNS4585:2025)

Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Шөнө (07-22 цаг)	8 цагийн дундаж	дБ (А)	45
Өдөр (22-07 цаг)	16 цагийн дундаж		60

Дуу чимээний хяналт мониторингийн цэгүүд - Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн хүрээнд дуу чимээний хяналт мониторингийн нийт 6 цэгийг төлөвлөлөө.

Хүснэгт № 10 Төслийн дуу чимээний хяналт мониторингийн цэгүүд

Дуу чимээний хяналтын цэгүүд	Хяналтын цэгүүдийн байршил	Урьдчилсан төлөвлөсөн цэгүүдийн координат
ДХЦэг1	Оффис	47 516864 UTM 4937403
ДХЦэг2	Баяжуулах үйлдвэр	47 519644 UTM 4936753
ДХЦэг3	Ил уурхай – 1	47 519878 UTM 4934316
ДХЦэг4	Ил уурхай – 2	47 522189 UTM 4934551
ДХЦэг5	Ил уурхай – 3	47 523146 UTM 4935652



Зураг 3 Дуу чимээний хяналт мониторингийн цэгүүд

6.9.2 Агаарын чанарын хяналт шинжилгээний хөтөлбөр

Төсөл хэрэгжүүлэгч нь Хотгор чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслөөс агаарын чанарт үзүүлж буй нөлөөллийг хянах, илрүүлэх зорилгоор агаарын чанарын хяналтын цэгийг агаар бохирдуулагч бодис ялгаруулж буй эх үүсвэр бүр дээр төлөвлөж, байнгын хяналт шинжилгээ хийх шаардлагатай. Ингэснээр төслөөс агаарын чанарт үзүүлж буй сөрөг нөлөөллийг эрт үед нь илрүүлэх, илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг үр дүнтэй боловсруулах боломж үүснэ.


Агаарын чанарын хяналт мониторингийн цэгүүд - Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн хүрээнд агаарын чанарын хяналт мониторингийн нийт 22 цэгүүдэд TSP, PM₁₀, PM_{2.5}, SO_x, NO_x, CO үзүүлэлтүүдийг хэмжихээр төлөвлөсөн.

Хүснэгт № 11 Төслийн агаарын чанарын хяналт мониторингийн цэгүүд

Агаарын чанарын хяналтын цэгүүд	Хяналтын цэгүүдийн байршил	Урьдчилан төлөвлөсөн цэгүүдийн координат
АХЦэг1	Ажилчдын кемп	47 514512 UTM 4939783

<i>АХЦэг2</i>	Уурхайн шороон зам дагуу – 1	47 515594 UTM 4937781
<i>АХЦэг3</i>	Оффис	47 516513 UTM 4937240
<i>АХЦэг4</i>	Баяжуулах үйлдвэрийн баруун урд	47 518551 UTM 4937024
<i>АХЦэг5</i>	Баяжуулах үйлдвэрийн зүүн хойно	47 520210 UTM 4937637
<i>АХЦэг6</i>	Тэсрэх материалын агуулах	47 514043 UTM 4934770
<i>АХЦэг7</i>	Авто зогсоол	47 515359 UTM 4934860
<i>АХЦэг8</i>	Ил уурхай – 1 баруун хойно	47 516333 UTM 4935545
<i>АХЦэг9</i>	Уурхайн шороон зам дагуу – 2	47 519182 UTM 4935707
<i>АХЦэг10</i>	Шатахуун түгээх станц	47 520643 UTM 4936086
<i>АХЦэг11</i>	Ил уурхай – 1 хойно	47 518641 UTM 4934715
<i>АХЦэг12</i>	Ил уурхай – 1 зүүн хойно	47 519705 UTM 4935329
<i>АХЦэг13</i>	Ил уурхай – 2	47 520805 UTM 4934968
<i>АХЦэг14</i>	Уурхайн шороон зам дагуу – 3	47 523973 UTM 4935311
<i>АХЦэг15</i>	Ил уурхай – 3 зүүн урд	47 522879 UTM 4935275
<i>АХЦэг16</i>	Ил уурхай – 3 баруун урд	47 522320 UTM 4935076
<i>АХЦэг17</i>	Хөрсний овоолго – 2 зүүн урд	47 522031 UTM 4934247
<i>АХЦэг18</i>	Хөрсний овоолго – 2 баруун урд	47 520985 UTM 4934175
<i>АХЦэг19</i>	Хөрсний овоолго – 1 зүүн урд	47 519687 UTM 4933417
<i>АХЦэг20</i>	Хөрсний овоолго – 1 урд	47 517884 UTM 4933435
<i>АХЦэг21</i>	Хөрсний овоолго – 1 баруун урд	47 516117 UTM 4933579
<i>АХЦэг22</i>	Шинэжинст сумын төв	47 521959 UTM 4932732

Урьдчилан төлөвлөсөн цэгүүдийн координат нь төслийн үйл ажиллагааны үед эх үүсвэрүүдийн төлөвлөлт, байршлаас хамааран өөрчлөгдөж болно.



Зураг 4 Агаарын чанарын хяналт мониторингийн цэгүүд

6.9.3 Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээний хөтөлбөр


Хөрс нь байгалийн чухал бүрэлдэхүүн хэсгийн нэг бөгөөд ургамлан нөмрөг, чулуулаг давхарга, уур амьсгал усан бүрхэвчийн зааг дээр оршдог өвөрмөц шинж чанартай, байгаль цаг уурын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөлөлд амархан өртдөг эргэн нөхөн сэргэх хугацаа удаан байдаг онцлогтой учраас экосистемийн төлөв байдлыг тодорхойлогч чухал бүрэлдэхүүн юм. Иймд төсөл хэрэгжүүлэгч нь Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлж буй нөлөөллийг хянах, илрүүлэх зорилгоор хөрсөн бүрхэвчийн хяналтын цэгийг хөрс бохирдуулж болзошгүй эх үүсвэр бүр дээр төлөвлөж, байнгын хяналт шинжилгээ хийх шаардлагатай. Ингэснээр төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлж буй сөрөг нөлөөллийг эрт үед нь илрүүлэх, илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг үр дүнтэй боловсруулах боломж үүснэ.

Хөрсний хяналт мониторингийн цэгүүд - Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн хүрээнд хөрсний хяналт мониторингийн нийт 13 цэгийг төлөвлөлөө.

1. Төслийн хөрсөн бүрхэвчийн хяналт мониторингийн цэгүүд

Хөрсөн бүрхэвчийн хяналтын цэгүүд	Хяналтын цэгүүдийн байршил	Урьдчилсан төлөвлөсөн цэгүүдийн координат	Хяналт шинжилгээ хийх давтамж
ХХЦэг1	Ажилчдын кемп	47 514199 UTM 4939790	Улиралд 1 удаа

<i>ХХЦэг2</i>	Оффис	47 517181 UTM 4937190	Улиралд 1 удаа
<i>ХХЦэг3</i>	Шатахуун түгээх станц 1	47 516472 UTM 4936862	Сард 1 удаа
<i>ХХЦэг4</i>	Уурхайн дотоод шороон зам дагуу	47 516599 UTM 4936263	Улиралд 1 удаа
<i>ХХЦэг5</i>	Баяжуулах үйлдвэрийн баруун хойно	47 518508 UTM 4937626	Улиралд 1 удаа
<i>ХХЦэг6</i>	Баяжуулах үйлдвэрийн урд	47 519108 UTM 4936735	Улиралд 1 удаа
<i>ХХЦэг7</i>	Баяжуулах үйлдвэрийн зүүн урд	47 520108 UTM 4936972	Улиралд 1 удаа
<i>ХХЦэг8</i>	Шатахуун түгээх станц 2	47 520854 UTM 4936044	Сард 1 удаа
<i>ХХЦэг9</i>	Ил уурхай – 3 урд	47 522617 UTM 4935063	Улиралд 1 удаа
<i>ХХЦэг10</i>	Хөрсний овоолго – 2 урд	47 521563 UTM 4934135	Улиралд 1 удаа
<i>ХХЦэг11</i>	Хөрсний овоолго – 1 урд	47 518890 UTM 4933426	Улиралд 1 удаа
<i>ХХЦэг12</i>	Авто зогсоол	47 515672 UTM 4934808	Улиралд 1 удаа
<i>ХХЦэг13</i>	Тэсрэх материалын агуулах	47 514236 UTM 4934590	Улиралд 1 удаа



Зураг 5 Хөрсний хяналт мониторингийн цэгүүд

6.9.4 Усан орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


Төсөл хэрэгжүүлэгч нь төслөөс усан орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг хянах зорилгоор гүний уснаас дээжлэлт хийн хяналт шинжилгээг гүйцэтгэнэ.

Усан орчны хяналт шинжилгээний цэгүүд - Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн хүрээнд 8 ширхэг цооногийг гидрогеологийн хайгуулын хүрээнд өрөмдөж тоноглогсон бөгөөд усны хяналт мониторингийг эдгээр усны эх үүсвэрүүд дээр төлөвлөлөө.

Хүснэгт № 12 Төслийн усны хяналт мониторингийн цэгүүд

Усны хяналтын цэгүүд	Хяналтын цэгүүдийн байршил	Хяналтын цэгүүдийн координат	Хяналт шинжилгээ хийх давтамж
CSB01	Ажилчдын кемпийн ойролцоо	47 514135.25 UTM 4940105	Улиралд 1 удаа
TB01	Ил уурхай – 1 баруун	47 514407.36 UTM 4935619	
TB02	Ил уурхай – 1 баруун хойно	47 515977.26 UTM 4935585	
TB03	Ил уурхай – 1 хойно	47 518964.38 UTM 4935360	

ТВ04	Ил уурхай – 2 хойно	47 521231.72 UTM 4935486	
ТВ05	Баяжуулах үйлдвэрийн баруун	47 517794.03 UTM 4937534	
ТВ06	Оффисын урд	47 517048.27 UTM 4936291	
ТВ07	Ил уурхай – 1 хойно	47 5172686.16 UTM 4935385	
Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн хаягдал ус	Цэвэрлэх байгууламжийн гаралтын ус	-	Дулааны улиралд 6-9 сард 1 удаа



Зураг 6 Усны хяналт мониторингийн цэгүүд

6.9.5 Ургамлан нөмрөгийн хяналт мониторингийн хөтөлбөр


Төсөл хэрэгжүүлэгч нь төслөөс ургамлан нөмрөгт үзүүлж буй нөлөөллийг хянах, илрүүлэх зорилгоор ургамлын нөмрөгийн хэмжилт хийх, дээж авах хяналтын цэгийг ургамлын бүлгэмдэл тус бүр дээр төлөвлөж, байнгын хяналт шинжилгээ хийх шаардлагатай. Ингэснээр төслөөс ургамлан нөмрөгт үзүүлж буй сөрөг нөлөөллийг эрт үед нь илрүүлэх, илрүүлсэн сөрөг нөлөөллийг үндэслэн тодорхой цаг хугацааны дотор байгаль хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг үр дүнтэй боловсруулах боломж үүснэ.

Ургамлан нөмрөгийн хяналт шинжилгээний цэгүүд - Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн хүрээнд 12 цэгт ургамлын хяналт мониторингийг

төлөвлөлөө. Төслийн талбайн хэмжээнд 6 ургамлын бүлгэмдэл тархсан бөгөөд бүлгэмдэл тус бүрээс 1 нөлөөлөлд өртөж болзошгүй цэг, 1 нөлөөлөлд өртөхгүй буюу харьцуулалтын сонголоо.

Хүснэгт № 13 Төслийн ургамлан нөмрөгийн хяналт мониторингийн цэгүүд

Ургамлан нөмрөгийн хяналтын цэгүүд	Хяналтын цэгүүдийн байршил	Хяналтын цэгүүдийн координат	Хяналт шинжилгээ хийх давтамж
УХЦэг1	Ил уурхай – 1 хойно	47 517311 UTM 4935766	Жилд 1 удаа 8-р сард нэг мониторингийн цэгт ойролцоо 3 удаагийн бичиглэл хийнэ.
УХЦэг2	Баяжуулах үйлдвэрийн баруун	47 517667 UTM 4937345	
УХЦэг3	Оффис	47 516600 UTM 4937430	
УХЦэг4	Ажилчдын кемп	47 515690 UTM 4939535	
УХЦэг5	Зогсоол	47 514666 UTM 4934870	
УХЦэг6	Ил уурхай – 1 баруун хойно	47 516131 UTM 4935482	
УХЦэг7	Төслийн талбайн баруун	47 511622 UTM 4938212	
УХЦэг8	Төслийн талбайн баруун	47 511494 UTM 4936122	
УХЦэг9	Төслийн талбайн баруун хойно	47 512504 UTM 4942764	
УХЦэг10	Төслийн талбайн зүүн	47 521364 UTM 4939564	
УХЦэг11	Шатахуун түгээх станц	47 520796 UTM 4935667	
УХЦэг12	Нисэх онгоцны буудал	47 517510 UTM 4940133	



Зураг 7 Ургамлын хяналт мониторингийн цэгүүд

6.9.10 Амьтны аймгийн хяналт мониторингийн хөтөлбөр

Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн талбай нь сумын төвийн ойролцоо учир ховор, нэн ховор амьтад, том туруутан амьтдын тархац нутагтай шууд давхцахгүй. Гэсэн хэдий ч төслийн нөлөөллийн бүс, түүний ойролцоо аргаль хонь, янгир ямаа, хар сүүлт зээрийн хэд хэдэн тасархайтсан популяцийн тархац нутаг бий. Мөн Говийн Их дархан цаазат газрын А хэсэгт дэлхийд ховордож буй Төв азийн эндемик зүйлүүд болох хулан адуу, мазаалай баавгай, цоохор ирвэс, хавтгай тэмээний тархацтай учир тэдгээрийг хамгаалах Олон улсын болон үндэсний хэд хэдэн байгаль хамгаалах төслүүд амжилттай хэрэгжиж байна. Энэ бүс нутагт мазаалай баавгай, хар сүүлт, цоохор ирвэс зэрэг амьтдад сансрын дамжуулагч бүхий хүзүүвч зүүхээс гадна уст цэгүүдэд автомат камер байршуулах судалгаанууд тогтмол хийгдэж байна. Иймд дээрх судалгаануудаас үндэслэн төслийн талбайн хүрээнд ойр орчимд амьтны аймгийн хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг уурхай ашиглалтын хугацаанд тодорхойлох шаардлагатай.

Амьтны аймгийн хяналт мониторингийн цэгүүд - Хотгорын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн хүрээнд амьтны хяналт мониторингийн дараах байдлаар гүйцэтгэвэл тохиромжтой.

Хүснэгт № 14 Төслийн амьтны аймгийн хяналт мониторингийн төлөвлөгөө

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Тайлбар
--------------------------------------	----------------------------	---------

Автомат камер ашиглах замаар зарим уст цэгүүдэд ирж буй амьтдын зүйл, нягтшиллыг үнэлэх	Сэгс цагаан богд уул орчмын булгууд, хөх дэрсний булаг гэх мэт	Нэг уст цэг дээр 2-оос цөөнгүй автомат камер байрлуулах
Зэрлэг амьтны тархац, нөөцийг үнэлэх зорилгоор шугаман замналын судалгаа хийх	Нарийвчилсан үнэлгээний тайлангийн амьтны судалгаа хийсэн замналын дагуу	
Мэрэгч амьтдын зүйлийн олон янз байдал, бүлгэмдлийг үнэлэх	Уурхайн ойролцоо болон уурхайн нөлөөллийн бүсийн гадна дээж талбай сонгох	Шерман загварын амьд баригч 50 ширхгийг мөр хооронд 20 метрийн зайтай шугамын дагуу байрлуулж баригдсан бүх амьтдын зүйлийг тодорхойлох
Шувуудын судалгаа, махчин шувуудын үүрний байршиллыг тогтоох	Талбайг жигд хамруулах байдлаар харууц цэг сонгох	Харууц цэг бүрд 1 цагийн ажиглалт хийж бүртгэл хөтлөх
Мөлхөгч болон сээр нуруугүй амьтдын зүйлийн олон янз байдлын судалгаа	Уурхайн бүсэд болон нөлөөллийн гадна дээж талбай сонгох	Амьтдын нягтшил, зүйлийн олон янз байдлыг үнэлэх


Хүснэгт № 15 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Зардал (1 жил),₮	Нийт зардал сая ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7
Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр							
1	Дуу чимээ	- Оффис 1 - Ил уурхай 3 - Баяжуулах үйлдвэр 1 - Шинэжиснт сумын төв 1	5		Хэмжилтийн багаж аван хэмжилтийг хийх:Багажны үнэ 5.0 сая	5.0	MNS4585:2025.
2	Агаарын чанар Орчны тоосжилт (PM _{2.5} , PM ₁₀ TSP, CO, NO ₂ , SO ₂)	- Ажилчдын кемп 1 - Оффис 1 - Уурхайн зам 2 - Ил уурхай 4 - Хөрсний овоолго 7 - Баяжуулах үйлдвэр 2 - ТМА 1 - Зогсоол 1 - ШТС 2 - Шинэжиснт сумын төв 1	22	7 хоногт 1 удаа	Хэмжилтийн багаж аван хэмжилтийг хийх: Багажны үнэ 35.0 сая Шинэжинст сумын төвд 1, уурхайн овоолго ухшын орчимд 2 агаарын чанарын станц байгуулах: ҮАЗ-д тусгах	35.0	MNS4585:2025 MNS ISO4227- 2002
3	Хөрсний хими болон физик Хүнд металл	- Ажилчдын кемп 1 - Оффис 1 - Уурхайн зам 1 - Хөрсний овоолго 3	13	Улиралд 1 удаа	1 дээж 28,100*13*4 Жилд 1,461,200	1.46	MNS 2305:1994 MNS 5850:2019

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Зардал (1 жил), ₮	Нийт зардал сая ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
4	Усан орчин Ерөнхий хими физикийн шинжилгээ Урвалын орчин (pH) Хүнд металлын шинжилгээ	- Баяжуулах үйлдвэр 3 - TMA 1 - Зогсоол 1 - ШТС 2	7	Улиралд 1 удаа	1 дээж 54,000*7*4 Жилд 1,512,000	1.5	MNS 0900:2018 MNS6148:2010 MNS ISO5667-11:2000.
		- CSB01 - TB01 - TB02 - TB03 - TB04 - TB05 - TB06 - TB07					
		Усан орчин					
		pH, БХХ, ХХХ, NH ₄ , Ж/б, NO _x					
5	Усан орчин	Ахуйн бохирын цэвэрлэх байгууламжийн ус	1	Дулааны улиралд 6-9 сард	1 дээж 20,000*1*4 Жилд 80,000	0.08	MNS4943:2015
6	Ургамлан нөмрөг Ургамлын зүйлийн бүрдэл Ургамлан нөмрөгийн бүрхэц	Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг болон алслагдсан цэгүүд	12	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах		Батлагдсан арга зүйн дагуу
7	Амьтдын аймаг Амьтдын нүүдэл шилжилтийн мониторинг Амьтдын тоо толгой	Төслийн талбай болон түүний ойролцоох уст цэг, мод бутлаг ургамал бүхий талбайд	5	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах		
Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр							

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Зардал (1 жил), ₮	Нийт зардал сая ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Агаарын чанар Орчны тоосжилт (PM _{2.5} , PM ₁₀ TSP, CO, NO ₂ , SO ₂)	Дотоод хяналт шинжилгээний цэгүүдэд	22	Жилд 1 удаа 5 жилд	1 дээж 100,000*22 Жилд 2,200,000	2.2	MNS4585:2025. MNS ISO4227- 2002
2	Хөрсний хими болон физик Хүнд металл	Дотоод хяналт шинжилгээний цэгүүдэд	13	Жилд 1 удаа 5 жилд	1 дээж 35,000*13 Жилд 455,000	0.455	MNS 2305:1994 MNS 5850:2019
3	Усан орчин Ерөнхий хими физикийн шинжилгээ Урвалын орчин (pH) Хүнд металлын шинжилгээ (Унд ахуйн худгийн усанд микробиологийн шинжилгээг хийлгэх)	Дотоод хяналт шинжилгээний цэгүүдэд	7	Жилд 1 удаа 5 жил	1 дээж 30,000*7 Жилд 210,000	0.21	MNS 0900:2018 MNS6148:2010 MNS ISO5667-11:2000.
4	Усан орчин pH, БХХ, ХХХ, NH ₄ , Ж/б, NO _x	Дотоод хяналт шинжилгээний цэгүүдэд	1	Жилд 1 удаа 5 жил	1 дээж 40,000*1 Жилд 40,000	0.04	MNS4943:2015
5	Ургамлан нөмрөг Ургамлын зүйлийн бүрдэл Ургамлан нөмрөгийн бүрхэц	Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг болон алслагдсан цэгүүд	12	Жилд 1 удаа 5 жил	2.0	2.0	Батлагдсан арга зүйн дагуу
6	Амьтдын аймаг Амьтдын нүүдэл шилжилтийн мониторинг	Төслийн талбай болон түүний ойролцоох уст цэг, мод бутлаг ургамал бүхий талбайд	5	Жилд 1 удаа 5 жил	3.0	3.0	

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Зардал (1 жил), ₮	Нийт зардал сая ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	Амьтдын тоо толгой						
	<i>Хамтын оролцоотой хяналт шинжилгээний хөтөлбөр</i>						
1	Орон нутгийн иргэдтэй хамтран дээж цуглуулах, шинжилгээний хариуг тайлагнах, мониторинг хийх			Үйл ажиллагааны зардалд тусгах			
	Нийт				50,945,000 төгрөг		



Зураг 8. Орчны хяналт мониторингийн цэгүүд

6.10 Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 2.2-т тусгасны дагуу төсөл хэрэгжүүлэгч Сэкер Ресорсус Монголиа ХХК нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон нэмэлт тодотгол үнэлгээний ажлын үр дүнгээр боловсруулан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үнэлгээний мэргэжлийн зөвлөл хэлэлцэн баталснаас хойш 1 сарын дотор тухайн жилийн БОМТ-г боловсруулан <https://www.eic.mn/> сайтаар материалуудаа цахимаар оруулан БОУАӨЯ-д батлуулахаар хүргүүлнэ. Үүний дараачийн тухайн жилийн БОМТ-г БОУАӨЯ-нд жил бүрийн 12 дугаар сарын 31-ний дотор хүргүүлнэ.

БОМТ-г уул уурхайн төслийн хувьд БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын хавсралт болох Уул уурхайн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах агуулгын хүрээнд боловсруулах нь зүйтэй.

Хүснэгт № 16 БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, сая төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	Баянхонгор аймгийн Шинэжинст сумын 1,2,4-р багийн Иргэд Нийтийн хуралд	БОМТ-ний хүрээнд гүйцэтгэсэн ажлын хураангуй	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн хураангуй танилцуулга	Тухайн жилд			Зараа, Уртын гол, Эхэнхавцгай багууд
2	Шинэжинст сумын Засаг даргын тамгын газарт			Тухайн жилд	Үйл ажиллагааны зардалд тусгав.	Байгаль орчны хэлтэс	Шинэжинст сум
3	Баянхонгор аймгийн байгаль орчны газар		Тухайн жил төлөвлөсөн гүйцэтгэсэн тайлан. Ажлын	11 дүгээр сарын 01-нээс өмнө			Баянхонгор аймаг
4	Байгаль Орчин, Уур Амьсгал Өөрчлөлтийн яам	Тайлангийн эх хувь албан бичгийн хамт	гүйцэтгэл, үрдүнтэй холбоотой фото зургаар баталгаажуулна	12-р сарын 30-наас өмнө			Улаанбаатар хот